



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.5 дах заалтын 19.5.2 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Засгийн газрын 2014 оны 382 дугаар тогтоолоор Эрүүл мэнд, спортын яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 399 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн”-ийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД  Г.ШИЙЛЭГДАМБА



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 26 өдрийн
27 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН



Комиссын дарга:

Төрийн нарийн бичгийн дарга

Орлогч дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга

Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга

Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл
мэнд, боловсролын хяналтын газрын Эрүүл
мэндийн хяналтын хэлтсийн дарга
(зөвшилцсөнөөр)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх
Эрүүл мэндийн даатгалын газрын дарга
(зөвшилцсөнөөр)